



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ЧУХАЛ СЭДЭВ

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТЭМДЭГЛЭЛ

2022 ОНЫ 12 ДУГААР САР

“ЭРҮҮГИЙН ПРОЦЕСС ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН БАТАЛГАА” ТЭМДЭГЛЭЛ

АРГА ЗҮЙ

Нээлттэй Нийгэм Форум нь эрх зүйн шинэчлэлийн үйл явцыг бодлогын хэлэлцүүлэг, судалгаагаар дэмжиж ажиллахыг зорьдог билээ. Энэ хүрээнд хүний эрхэд суурилсан, шударга процесс бүхий эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор “Эрүүгийн процесс ба Хүний эрх” цуврал хэлэлцүүлгийг эхлүүллээ. Эдгээр хэлэлцүүлэг нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэд хэдэн хуулийн төслийг УИХ хэлэлцэж байгаа үетэй давхцаж буйгаараа онцлог юм. Цуврал хэлэлцүүлгийн зорилго эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шатанд тулгамдаж буй хүний эрхийн асуудлыг хөндөхөд оршиж байгаа бөгөөд хэлэлцүүлгийг ХЭҮК, ХЗДХЯ, МХХ, МӨХ-той хамтран зохион байгуулж байгаа билээ. Энэ удаагийн хэлэлцүүлэг “Эрүүгийн процесс дахь хүний эрхийн баталгаа” сэдвийн хүрээнд өрнөсөн бөгөөд түүний тэмдэглэлийг сийрүүлэн Та бүхэнд хүргэж байгаадаа баяртай байна.

ЭРҮҮГИЙН ПРОЦЕСС ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН БАТАЛГАА

ЕРӨНХИЙ ТОЙМ

Эрүүгийн эрх зүйн шинэчлэл 1993 оноос эхэлж, энэ хугацаанд хоёр удаа эрүүгийн хууль тогтоомжийг шинэчлэн найруулж баталсан бөгөөд холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажил үргэлжилсээр байна. Уг шинэчлэлийн зорилт нь хүний эрхэд нийцсэн, шударга процесс бүхий эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бэхжүүлэх явдал бөгөөд энэ хэлэлцүүлгээр эрүүгийн процесст хүний эрхийн баталгаа хэр хангагдсан болохыг хэлэлцэж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх арга зам эрэлхийлэхийг зорилоо.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ, 2-р бүлэг, 16 дугаар зүйл

13/халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ...;

14/ Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, ... эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно;

ИРГЭНИЙ БОЛОН УЛС ТӨРИЙН ЭРХИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ПАКТ**7 дугаар зүйл**

Хэнд ч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно. Тухайлбал, өөрийнх нь чөлөөтэй өгсөн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилтад оруулж болохгүй.

9 дүгээр зүйл

1. Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасаж болохгүй.

2. Баривчлагдсан шалтгааныг хүн бүрд баривчлах үед нь мэдэгдэхийн зэрэгцээ буруутгаж байгаа аливаа үндэслэлийг даруй мэдэгдэнэ.

3. Баривчлагдсан буюу эрүүгийн хэрэгт буруутгагдсан аль ч хүнийг шүүгч буюу хуулийн дагуу шүүн таслах эрх хэмжээ олгогдсон бусад албан тушаалтанд даруй шилжүүлэх бөгөөд хүн хэргээ боломжийн богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх буюу суллагдах эрхтэй. Шүүхийн өмнөх шатанд байгаа хүнийг заавал цагдан хорьж байх нийтлэг журам байх албагүй бөгөөд шүүх хуралд оролцох, шүүн таслах ажиллагааны аль ч шатанд байлцах, шаардлагатай тохиолдолд, шүүхийн шийдвэр гүйцэтгэхэд байх баталгаа гаргаж өгсөн бол этгээдийг суллаж болно.

4. Баривчлагдаж, эсхүл цагдан хоригдож эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр ийнхүү хорьж саатуулсан нь хууль ёсны эсэхийг шүүхээр даруй тогтоолгох, хууль бусаар хорьсон бол суллуулах шийдвэр гаргуулах эрхтэй.

5. Хууль бусаар баривчлагдаж, эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй.

10 дугаар зүйл

1. Эрх чөлөөгөө хасуулсан бүх хүнтэй хүнлэг харьцаж, угаас заяасан нэр төрийг нь хүндэтгэнэ.

2. (а) онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд буруутнаар татагдсан этгээдийг ял шийтгүүлсэн этгээдээс тусгаарлаж, шийтгэгдээгүй этгээдийн эрх зүйн байдалд тохирсон жич дэглэмд байлгана.

(b) буруутнаар татагдсан насанд хүрээгүй этгээдийг насанд хүрсэн этгээдээс тусгаарлаж, хэргийг нь аль болох богино хугацаанд шүүхэд шилжүүлэн шийдвэрлүүлнэ .

3. Хорих байгууллагын дэглэмийн нэн чухал зорилго нь хоригдлыг засан хүмүүжүүлж, нийгмийн хэвийн гишүүн болгох явдал байна. Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүйчүүдийг насанд хүрэгсдээс тусгаарлаж, тэдний нас, эрх зүйн байдалд нийцсэн дэглэмд байлгана.

14 дүгээр зүйл

...

2. Эрүүгийн хэрэгт буруутгуулж буй хэн боловч гэм буруу нь хуулийн дагуу нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох эрхтэй.

3. Хүн бүр өөрийг нь яллагдагчаар татсан аливаа эрүүгийн хэргийг хянан хэлэлцэхэд бүрэн тэгш эрхийн үндсэн дээр дараах наад захын баталгаагаар хангагдах эрхтэй:

(а) оногдуулж байгаа ялын шинж чанар, үндэслэлийг ойлгох хэлээр нь даруй, нарийвчлан мэдэгдэх;

(b) өмгөөлүүлэх ажлаа бэлтгэх хүрэлцээтэй хугацаа, бололцоотой байх, сонгож авсан өмгөөлөгчтэйгөө харилцах;

...

(d) хэргийг нь шүүхээр хянан хэлэлцэхэд байлцах, өөрийгөө биечлэн өмгөөлөх буюу өөрийн сонгон авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх; өмгөөлөгчгүй байгаа бол өмгөөлүүлэх эрхийнх нь тухай өөрт нь мэдэгдсэн байх; шүүн таслах ажлын эрх ашиг шаардаж байвал ямар ч тохиолдолд, өөрт нь томилсон өмгөөлөгчтэй байх, ийм аливаа тохиолдолд өмгөөлөгчийн хөлсийг төлөх хүрэлцээтэй мөнгө хөрөнгө байхгүй бол үнэ төлбөргүй үйлчлүүлэх;

...

(g) өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, бурууг хүлээх тулган шаардалтад өртөхгүй;

26 дугаар зүйл

Бүх хүн хуулийн өмнө тэгш байх бөгөөд аливаа алагчлалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулах эрхтэй. Энэ үүднээс аливаа байдлаар алагчлах явдлыг хуулиар хориглох бөгөөд хууль нь арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн байдал буюу бусад байдлаар алагчлахаас бүх хүнийг адил тэгш, үр нөлөөтэй хамгаалах баталгааг бүрдүүлэх ёстой.

ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БУЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦ**13 дугаар зүйл**

Оролцогч улс, түүний нутаг дэвсгэрт эрүүдэн шүүгдсэн хэмээн мэдүүлж буй этгээд эрх бүхий байгууллагад гомдол гаргах, хэргээ шуурхай, шударгаар хянан шалгуулах явдлыг хангана. Гомдол гаргасан этгээд болон гэрчүүдийг гомдол гаргасан болон нотлох баримт гаргаж өгсөнтэй холбогдуулан зүй бусаар харьцах, айлган сүрдүүлэхээс хамгаалах арга хэмжээ авна.

14 дүгээр зүйл

1. Оролцогч улс өөрийн эрх зүйн тогтолцоогоороо эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга, хангалттай нөхөн төлбөр авах эрх, түүний дотор эрүүл мэндээ бүрэн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө. Эрүүдэн шүүгдсэний улмаас хохирогч нас барвал асран халамжлагч нөхөн төлбөр авах эрхтэй.

2. Энэхүү зүйл нь хохирогч буюу бусад этгээд дотоодын хууль тогтоомжийн дагуу нөхөн төлбөр авах эрхийг хөндөхгүй.

15 дугаар зүйл

Оролцогч улсууд эрүү шүүлтийн улмаас хийсэн гэж тогтоогдсон мэдэгдлийг шүүн таслах аливаа ажиллагаанд нотлох баримт болгохгүй, харин эрүү шүүлт тулгасан хэмээн буруутгагдсан хүний эсрэг мэдэгдэл хийгдсэн тухай нотлох баримт болгон ашиглаж болно.

Гэмт хэрэгтэй тэмцэх зорилгын хүрээнд төрийн хүчирхэг механизм ажиллаж байгаа тул гэмт хэрэгт шалгагдаж байгаа хүний Үндсэн хууль, олон улсын гэрээгээр хамгаалагдсан үндсэн эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах зорилгоор эрүүгийн процессыг нарийн журамлах шаардлагатай буюу due process гэдгийг тогтоодог. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг сонгодог үзэл санаагаар нь авч үзвэл яллагдагч, түүний өмгөөлөгч нэг талд, нөгөө талд мөрдөгч, прокурорын асуудлууд зохицуулагдаж явдаг учиртай. Шударга байдлыг хангах үүднээс хохирогчид эрх олгож, баталгаагаар хангана. Гэхдээ үүний цаана нэг ноцтой философийг орхиж болохгүй, энэ нь хохирогч бол хэргийн талаар гэрчилж байгаа хүн юм. Зарим тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэт гуйвуулж, хохирогч бүгдийг үнэн ярьдаг мэт хандаж, хохирогчийн мэдүүлгийг шалгах ч шаардлагагүй, шууд нотлох баримтаар тооцох ёстой юм шиг хандлага бий болж, улмаар хүнийг хэлмэгдүүлэх эрсдэл үүсдэг. Тиймээс сонгодог утгаараа энэ процесст сэжигтэн, яллагдагчийн эрх ашгийг хамгаалах асуудал туссан байх ёстой болохыг анхаарах нь зүйтэй. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль үндсэндээ хэрэгт шалгагдаж байгаа хүний эрхийг баталгаатай хангах зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд талуудын оролцоог хангах, гомдол гаргах замаар процессын алдааг зөвтгөх, залруулах боломжтой байхаар бичигдсэн. Үүний төлөө прокурорын хяналт болон зөвшөөрөл, шүүхийн зөвшөөрөл, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хэлэлцүүлэг, гэрч, хохирогчийг хамгаалах хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг гэсэн процесс хуульчлагдсан. Процессын бүх шат ил тод, бүх шатанд гомдол гаргаж болохоор, үр дүнг эргэж хэлэлцэх, засаж залруулах, зөвтгөх бололцоотой байдлаар журамласан нь хүний эрхийн баталгаа болж байгаа хэрэг юм.

Прокурорын хяналт бол хүний эрхийг хангах механизмын нэг бүрэлдэхүүн хэсэг мөн. Хүний эрхийн зөрчлийг олж илрүүлэн, таслан зогсоох нь прокурорын нэг гол үүрэг. Эрүү шүүлт тулгасан эсэхийг тогтоох практикт тулгарч буй асуудал бол нотлох баримтгүй байгаа явдал юм. Үйлчлүүлэгчийн хувьд намайг айлган сүрдүүлсэн, цохисон, хууран мэхэлсэн, надад уншуулаагүй гарын үсэг зуруулсан гэх мэт зүйл хэлдэг ч өмгөөлөгч оролцоогүй процесс яаж явагдсан нь ойлгомжгүй, магадгүй, зарим тохиолдолд дэгсдүүлж байхыг ч үгүйсгэхгүй. 2017 оны хуульд “Мэдүүлгийг шаардлага хангасан, зөвшөөрөлтэй өрөөнд авна” гэж зохицуулсан. Гэтэл мөрдөгч ажлынхаа өрөөнд л мэдүүлэг авч байна. Нөгөө хүний эрх, хувийн нууцтай холбоотой асуудал хөндөгдөхийн зэрэгцээ өмгөөлөгч суух сандалгүй нөхцөлд мэдүүлэг авагдаж байна. Энэ тохиолдолд мэдүүлгийг цахим хэрэгслээр баримтжуулах боломжгүй байгаагаас эрүүдэн шүүгдсэн эсэхийг нотлоход хүндрэл учирч байна. Тиймээс цаашид хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх асуудалд онцгой анхаарах шаардлагатай.

Хоёр. БАРИВЧЛАХ АЖИЛЛАГАА, ЦАГДАН ХОРИХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

“МАНААЧ” ЖҮЖГИЙН ТАНИЛЦУУЛГА¹



¹ Т.Бум-Эрдэнэ, Б.Онон. “Манаач” теле жүжиг. Нээлттэй Нийгэм Форум, Глоб Интернэшнл төв, МҮОНТ, https://www.youtube.com/watch?v=y_b_eWZTfJk

Шүүгчийн зөвшөөрөлгүйгээр баривчилсан үед өмгөөлөгчтэйгөө холбоо тогтоох боломж нөхцөлийг хязгаарлах, үйлчлүүлэгч нь хаана байгаа нь мэдэгдэхгүй байх зэрэг хууль бус үйлдлүүд практик дээр гарч байна. Өмнөх хуулиар баривчилсан тохиолдолд 48 цагийн дотор гэр бүлийн гишүүн, өмгөөлөгчид мэдэгдэх байсныг шинэ хуулиар 6 цагийн дотор мэдэгдэхээр зохицуулсан нь хүний эрхийг хамгаалах талаасаа олон улсын гэрээ конвенцод нийцүүлсэн чухал алхам юм. Тиймээс тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэхгүй байгаа үйлдлийг таслан зогсоох, сэжигтний эрх зүйн байдлыг хамгаалах үүднээс хуульд тодорхой зохицуулалт нэмж тусгах, эрх бүхий субъектүүд хүний эрхийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын механизмыг хуульд тодорхой заах шаардлагатай. Одоогоор прокурорт гомдол гаргаад л өнгөрч байна.

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ бол эрүүгийн процесс дахь хамгийн хүнд хэлбэрийн таслан сэргийлэх арга хэмжээ тул олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд “Шүүхийн өмнөх шатанд байгаа хүнийг заавал цагдан хорьж байх нийтлэг журам байх албагүй” хэмээн хязгаарласан байдаг. Манай улсын хувьд 2002 оны хуультай харьцуулахад 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд цагдан хорих нөхцөл илүү өргөн хүрээнд хуульчлагдсан хэмээн иргэний нийгмийн байгууллагаас шүүмжилдэг. Харин өмнөх Эрүүгийн байцаан шийтгэх хуультай харьцуулахад шинэ хуулийн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл нь хүний эрхийг хангаж, хамгаалах талаасаа сайн зохицуулалтууд орж ирсэн ч “Гэмт хэрэг үйлдэж болзошгүй” гэдэг үндэслэлээр цагдан хорихоор байгаа нь хүний эрх зөрчиж байна гэж өмгөөлөгчид үздэг.

Ажиглалтаас үзэхэд цар тахлын хатуу хөл хорионы үеэр энэ төрлийн зөрчил нэлээд гарсан байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа зарим тохиолдолд зогссон гэж судалгаанд оролцсон зарим хүн үзсэн. Тухайлбал, гэрч, хохирогчийг хамгаалах тогтоол гаргах, прокурорын байгууллагаар орох, мөрдөгч өөрөө шийдвэр гаргах, прокурор зөвшөөрөл өгөх ажиллагаа бүхэлдээ зогссон гэдэг бол маш ноцтой зүйл юм. Бидэнд тулгарч буй сорилт юу вэ гэхээр хуулийн зохицуулалтууд бүгд биечлэн уулздаг байхаар буюу 70, 80 жил ажиллаж ирсэн системээр бичигдсэн. Тиймээс цар тахлын үед уг систем ажиллахгүй болчихсон хэрэг. Тиймээс цаашдаа цахим зөвшөөрөл, цахимаар мэдээлэл солилцох зэрэг хэлбэрт шилжих шаардлагатай. Энэ бол цэвэр үйл ажиллагааны зохион байгуулалт, менежментийн асуудал юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хүний эрхийг хангах талаас хэд хэдэн гол институт байна. Үүнд:

1. Зөвшөөрлийн тогтолцоо.
2. Хугацаа, тухайлбал, 6; 48 цаг гэж тодорхой хугацаа заасан.
3. Гомдол хүсэлт гаргах эрхүүд. Үүгээр дээд шатны албан тушаалтан болон прокурор хэрхэн хянаж хариу өгөхийг зохицуулсан.
4. Хэлэлцүүлэг, тухайлбал, цагдан хорих, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг гэх мэт.
5. “Даруй буюу боломжит хамгийн бага хугацааг хэлнэ” гэх зохицуулалт.

Тиймээс хуульд заасан хугацаанд ар гэрт нь мэдэгдээгүй бол хүний эрхийн зөрчлийг арилгах, зөвтгөх боломжийг “Гомдол, хүсэлт гаргах” гэсэн хэсэгт зохицуулж өгсөн.

2017 оны хуульд байгаа нэг шинэлэг зохицуулалт бол 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар өмгөөлөгчид мэдэгдэхгүйгээр цагдан хорих хугацааг сунгадаг байсныг өөрчилсөн явдал юм. Үүний дүнд цагдан хорионы хуралд өмгөөлөгч тодорхой бэлтгэлтэйгээр оролцож, үйлчлүүлэгчийнхээ хувийн байдалтай холбоотойгоор таслан сэргийлэх бусад арга хэмжээ авах тухай үндэслэл бүхий баримт нотолгоо гаргах боломж нээгдсэн.

Цагдан хорих ажиллагаатай холбоотой НҮБ-ын 20 гаруй гэрээ, конвенц байдгаас 7-8-д нь

Монгол Улс нэгдэн орж, соёрхон баталсан. Тиймээс олон улсын гэрээ конвенцод нийцүүлэх үүднээс цагдан хорих хугацаа 24 сар байсныг 18 сар болгосон нь хүний эрхийг хангах талаасаа дэвшилттэй алхам болсон. Мөн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээнд өмгөөлөгчийн үүрэг, оролцоог нэмсэн, тухайлбал, өмгөөлөгч үйлчлүүлэгчтэйгээ цаг тухайд нь ганцаарчлан уулзах, зөвлөгөө өгөх, таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авах зэрэг болно. Харин практикт энэ баталгаа хангалттай хэрэгжихгүй байгаа талаар судлаачид дүгнэж байна. Тухайлбал, баривчлагдсан, цагдан хоригдсон хүмүүстэй уулзах гэхэд өмгөөлөгчийн эрхийг хязгаарласан, өмгөөлөгчийн баталгааг эдлүүлээгүй, өмгөөлөгчийн биед халдсан зэргийг дурдаж болно. Энэ нь процесст хүний эрхийн баталгаа хангалтгүй байгааг илтгэнэ. Мөн хуульд тухайн этгээд цагдан хоригдож байхад сонгосон өмгөөлөгч нь ирээгүй бол томилогдсон өмгөөлөгчийг оролцуулаад шийднэ гэсэн зохицуулалт шинээр туссан. Энэ нь Үндсэн хуульд заасан өөрөө өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах, өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох эрхтэй зөрчилдөж байна. Цаашид өөрийнх нь өмгөөлөгчийг иртэл тодорхой хугацаагаар хүлээдэг байх зохицуулалтыг хуульд тусгах шаардлагатай.

Цахимаар саналаа хэлсэн оролцогчийн мэдээлэл

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.2 зүйлийн 3 дахь хэсгийн яллагдагчийг гэдгийг яллагдагч, шүүгдэгчийг гэж нэмэлт өөрчлөлт оруулж өгөхгүй бол шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулж, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг шүүх хүссэн хугацаагаараа буюу хуулийн ямар ч хязгаарлалтгүйгээр авч, дөрөв, таван жилээр цагдан хорих асуудал гарч байна.

Дээд хугацаа нь 18 сар гээд заасан байтал хэтрээд явж байгаа хэд хэдэн удаагийн тохиолдол ХЭҮК-ын судалгаагаар гарсан. Шүүгдэгч дээр цагдан хорионы хугацаа тоологдохгүй байгаа нь хүний эрхийн ноцтой зөрчил юм.

Зарчмын зөрүүтэй ойлголт, тайлбар

Яллагдагч, шүүгдэгчийн эрх зүйн байдлыг тусад нь оруулж өгөх асуудал хөндөгдлөө. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар бүлэгт яллагдагчийн эрх, үүргийг заасан. Өмнөх хуульд яллагдагч, шүүгдэгч, ялтан гэсэн нэршлийг тодорхой заасан байтал шинэ хуулиар ухарсан. Өнөөдөр яллагдагч, шүүгдэгч нь холилдсон тул оюутнуудад хэрхэн заах нь ойлгомжгүй болсон. Яллагдагч, шүүгдэгч гээд тусдаа оролцогч байна хэмээн нэрлэдэг хэр нь эрх, үүргийг нь салгаад хэлэх гэхээр хуульд нэг байгаад байна.

ЭХХШТХ-ийн 7.1 дүгээр зүйлийн 2-т “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа шүүгдэгчид энэ бүлэгт заасан эрх, үүрэг нэгэн адил хамаарна” гэсэн нь шүүгдэгчийн эрх зүйн байдлыг тогтоосон зохицуулалт юм.

Засгийн газраас боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тус хуулийн 14.1 буюу таслан сэргийлэх арга хэмжээ гэсэн зохицуулалт дээр 5 дахь хэсэг нэмж тусгасан. Энэ зүйлийн 1.2, 1.3, 1.5 буюу тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, мөн хязгаарлалт тогтоох, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлэх нөхцөлийг шүүх хангана гэж заасан. Ингэснээр баяр наадмын өдрүүд болон амралтын бусад өдрүүдээр таслан сэргийлэх арга хэмжээ авах үйл ажиллагаа тасралтгүй явагдах нөхцөл бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, 24 цагийн шүүхийн ажиллагаа бий болгохыг зорьж буй хэрэг юм.

Гурав. ЭРҮҮДЭН ШҮҮЖ АВСАН НОТЛОХ БАРИМТЫГ ТООЦОХГҮЙ БАЙХ

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцод заасан эрүүдэн шүүж олж авсан нотлох баримтыг тооцохгүй байх шаардлага Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.15 дугаар зүйлд бүхлээрээ туссан. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг дээр хууль бусаар цуглуулсан нотлох баримтын асуудал, хууль бус нэгжлэг, үзлэг хийж хурааж авсан битүүмжилсэн эд хөрөнгийн асуудал, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байхад хүний эрхийг зөрчсөн асуудал, эрүү шүүлт тулгаж, нотлох баримт цуглуулсан асуудлыг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр шийдвэрлэж чадахгүй бол гэм буруугийн хурлаар шийдвэрлүүлэхээр шилжүүлж болохоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31-р зүйлд заасан байсныг тус хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр эдгээр асуудлыг заавал шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр шийдвэрлэж дуусгаад гэм буруугийн хуралд шилжүүлэхээр заасан нь маш том дэвшил болсон.

Өмнө нь шүүхийн практикт эрүү шүүлт тулгасан, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчиж нотлох баримт цуглуулсан, хөрөнгө хураан авах, битүүмжлэх ажиллагааг хууль зөрчиж явуулсан асуудлыг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр гаргаж тавиад байхад шүүгч уг асуудлыг гэм буруугийн хурлаар шийдүүлэхээр шилжүүлж, улмаар эрүү шүүлт тулгаж цуглуулсан нотлох баримтын асуудлыг шийдэхгүйгээр гэм буруугийн асуудлыг шийдээд, ял оногдуулаад яваад байсан нь маш ноцтой хуулийн завхрал болсон.

Тиймээс шинэ өөрчлөлтөөр шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг дээр өмгөөлөгч эрүү шүүлт тулгаж нотлох баримт цуглуулсан гэсэн асуудлыг гаргаж тавиад, прокурор үүнийг нь үгүйсгэж чадаагүй бол тухайн нотлох баримтыг хэргээс хасуулж хэргийг буцаах, эсхүл эдгээр нотлох баримт хүчингүй гэж тооцчихоод гэм буруугийн хурал руу шилжих ёстой.

Зарчмын зөрүүтэй байр суурь

Иргэний нийгэм	Хуульч
<p>Иргэний нийгмийн байгууллагууд процессын хуульд байгаа энэ зохицуулалт бол нотлох баримтад тооцохгүй байх асуудал бүрэн тусаагүй гэсэн шүүмжлэлтэй байдаг. Тухайлбал, “16.12-р зүйл. Эрүү шүүлт тулгаж авсан нотлох баримтыг нотлох баримтаар тооцохгүй байх” гэсэн ч 16.12.1-д “энэ хуулийн 16.11-р зүйлд заасан журмаар нотлох баримтаар тооцохгүй” гэсэн. Тухайн 16.11-р зүйлд шүүх хянан шийдвэрлэж, нотлох баримтаар тооцох эсэхийг шийдэхээр байгаа. Гэтэл эрүүдэн шүүж олж авсан бол нотлох баримтаар тооцохгүй гэдэг нь хатуу зарчим. Цаашид хуулийг боловсронгуй болгох явцдаа үүнийг бас анхаарч үзэх нь зүйтэй.</p>	<p>Нотлох баримтаар тооцохтой холбоотой 16.11-р зүйл бол хууль зөрчиж цуглуулсан нотлох баримтын тухай асуудал. Өөрөөр хэлбэл, хуульд заасан журам зөрчиж мэдүүлэг авсан, өмгөөлөгчийг оролцуулах ёстой байтал оролцуулахгүйгээр мэдүүлэг авсан гэсэн асуудлууд байгаа. 16.12 бол тэр чигээрээ эрүү шүүлттэй холбоотой тул 16.12-р зүйл 16.11-р зүйлд хамаарахгүй. Өөрөөр хэлбэл, эрүү шүүлт тулгаж, бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий харилцаж мэдүүлэг авсан нь тогтоогдвол 16.11-р зүйлд заасан журмаар тооцохгүй. Яагаад “журмаар” гэсэн бэ гэхээр нотлох баримт цуглуулах ажиллагааны тодорхой хэсэг нь тооцогдохгүй болоод, эрүү шүүлт тулгасан эсэхтэй холбоотой хэсэг нь тооцогдохгүй болоход тухайн нотлох баримт цуглуулах ажиллагаа өөрөө удаан хугацаанд үргэлжилсэн хэд хэдэн нотлох баримт цуглуулсан. Жишээ нь, процесс байлаа гэхэд хууль зөрчөөгүй эсэх нь бүхэлдээ биш, зарим хэсэг нь нотлох баримтаараа тооцогдож үлдэх тийм боломжийг нээхийн тулд “16.11-р зүйлд заасан журмаар” гэж заасан. Түүнээс биш эрүү шүүлт тулгасныг нотлох баримтаар тооцох эсэхийг хэлэлцэх тухай биш юм.</p>

Дөрөв. ЭРҮҮГИЙН ПРОЦЕССТ ХҮНИЙ ЭРХ ЗӨРЧИГДСӨН ТОХИОЛДОЛД ХАРИУЦЛАГА ТООЦОХ АСУУДАЛ

Эрүүгийн хууль, 2015 он

13.4 дүгээр зүйл. Хүнийг хүчээр алга болгох

2. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгч хүнийг хууль бусаар хорьсон, хууль бусаар нууж эрх чөлөөг нь хязгаарласан, эсхүл хорьсон, эрх чөлөөг нь хязгаарласан талаарх мэдээллийг нууж, мэдээлэл өгөхөөс татгалзаж эрх чөлөөг нь хязгаарласны улмаас бусдын хууль ёсны эрх, ашиг сонирхолд нь хохирол, хор уршиг учруулсан нь энэ хуулийн тусгай ангид заасан бусад гэмт хэргийн шинжгүй бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

13.9 дүгээр зүйл. Хууль бусаар баривчлах, саатуулах

1. Эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж хүний эрх чөлөөнд халдсан, баривчилсан, саатуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он

1.13 дугаар зүйл. Шүүхэд хандах

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүн, хуулийн этгээд хуулиар хамгаалагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, хөндөгдсөн гэж үзвэл уг эрхээ сэргээлгэхээр шүүхэд хандах эрхтэй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.13-р зүйлд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүн, хуулийн этгээд хуулиар хамгаалагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, хөндөгдсөн гэж үзвэл уг эрхээ сэргээлгэхээр шүүхэд хандах эрхтэй” гэсэн маш том баталгаа оруулж өгсөн. Гэвч процессын хамгаалалтыг ашиглахгүй байгааг цаашид анхаарах шаардлагатай.

Мөн Эрүүгийн хуульд хүнийг хүчээр алга болгох, хууль бусаар баривчлах гэсэн хоёр төрлийн гэмт хэргийг зааж өгсөн нь процесс дахь хүний эрхийн тун чухал хамгаалалт юм. Тухайлбал, баривчилсан хүний талаар гэр бүл, өмгөөлөгчдөд 6 цагийн дотор мэдэгдэх үүргээ биелүүлэхгүй байх нь дээр дурдсан гэмт хэргийн шинжийг агуулж байна. Тиймээс ЭХХШТХ-ийн 1.13-р зүйлийг бариад явбал тухайн зөрчил цаашлаад эрүүгийн гэмт хэрэгт тооцогдох эрсдэл байгаа тул процессын журам хатуу мөрдөгдөхөд чухал хөшүүрэг болох учиртай.

Тав. ХОХИРОЛ БАРАГДУУЛАЛТ

Эрүүгийн процессын хүний эрхийн нэг чухал баталгаа бол энэ процессын явцад эрх нь зөрчигдсөн хүний эрхийг сэргээж, хохирлыг барагдуулах асуудал юм. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45-р бүлгээр “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах” гэсэн маш чухал зохицуулалт тусгасан нь чухал баталгаа юм.

МКХ-ноос 2019-2020 онд тус бүлгийн хүрээнд судалгаа хийж, эрүүгийн процесст эрх нь зөрчигдсөн гэж үзэн иргэний шүүхээр шийдвэрлүүлсэн 45 тохиолдлыг судалсан.² Энд тулгарч буй

2 Монголын криминологичдын холбоо. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45-р бүлгийн хэрэгжилт (Бодлогын судалгаа). Нээлттэй Нийгэм Форум, УБ., 2021. <https://forum.mn/product/211347>; Н.Норовсамбуу, Ж.Содномдаржаа. Хохирлын үндэсний тогтолцоо – Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад учирсан хохирлын нөхөн төлүүлэлт (Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ). Цуврал судалгаа №3, Нээлттэй Нийгэм Форум, УБ., 2021. <https://forum.mn/product/152598>

гол асуудал бол заавал мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагаанаас болж эрх нь зөрчигдсөн гэдгийг тогтоох шаардлага үүссэн явдал юм. Энэ нь эрх зүйн хувьд ухралт болсон. Үүний улмаас жилд 300-400 орчим нэхэмжлэх эрх үүсэхээр байгаа ч гурван жилд нийт 45 тохиолдол үүссэн гэхээр жилд 12-13 хэрэг л үүсжээ. Гэхдээ Улсын дээд шүүхийн дэвшилттэй гэж үзэхүйц 2-3 шийдвэр гарсан бөгөөд тухайн шийдвэрт хууль зөрчсөн эсэхийг тогтоох шаардлагагүй гэж үзжээ. Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар бүлэгт орсон 2020 оны нэмэлт, өөрчлөлт нь зарим талаар ухралт болсон байна.

Энэ хүрээнд хуульд туссан нэг чухал зохицуулалт бол ЭХХШТХ-ийн 45.7-р зүйл дэх “Хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг тайлбарлах” гэсэн заалт юм. Нэг ёсондоо цагаатгах тогтоол гаргасан бол энэ шийдвэрийг хүргүүлэхдээ хохирлоо нөхөн төлүүлэх журмыг тайлбарласан хуудсыг хамт хүргүүлэхээр зохицуулсан. “Иргэн бүр хуульч байх албагүй. Иргэн яаж хохирлоо барагдуулах юм бэ гэдэг арга замыг нь зааж өгөх ёстой” гэж хуулийн процесст тусгаад өгсөн нь маш том ахиц дэвшил юм. Энэ хүрээнд өөр нэг анхаарах асуудал бол тодорхой хэргийг шалгаж дуусаад тухайн хүн хэрэгт холбогдолгүй болсон, цагаадсан, хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд мөрдөгч, прокурор тухайн хүнд энэ эрхийг тайлбарлах соёл, дадлыг төлөвшүүлэх шаардлагатай. Гэвч судалгаанд оролцсон дийлэнх иргэд хэргээс салсандаа сэтгэл ханаад гомдол, нэхэмжлэл гаргадаггүй гэснийг анхаарах нь зүйтэй.

Дараагийн нэг анхаарах асуудал бол хохирлыг тогтоохдоо асар зөрүүтэй хандаж буй явдал юм. Тухайлбал, цагдан хоригдсон хоногийн нөхөн олговор тооцохдоо нэг өдрийг нэг өдрийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс эхлээд нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцсон байна. Цаашдаа хууль бусаар цагдан хоригдсон хоног тутмыг тооцох жишиг аргачлал боловсруулан хөгжүүлэх нь зүйтэй. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцод хохирол барагдуулахтай холбоотой маш чухал заалтууд байгаа. Тухайлбал, шударга хангалттай нөхөн төлбөр авах, түүний дотор эрүүл мэндээ бүрэн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө, эрүүдэн шүүгдсэний улмаас хохирогч нас барвал асран халамжлагч нь нөхөн төлбөр авах эрхтэй гэх мэтээр зохицуулсан. Гэвч хохирлын нөхөн төлбөр олгож байгаа өнөөдрийн практик энэ зарчимд нийцэхгүй байгаа тул цаашид зохицуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэй.

Эрүүгийн эрх зүйн дараагийн нэг зорилго бол гэмт хэрэгт хохирсон хүний хохирлыг нөхөн төлүүлж, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх явдал юм. Энэ зарчмын дагуу Эрүүгийн хуульд 6.7 дугаар зүйлийг хуульчилсан. Гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн, гэм буруугаа хүлээсэн хүнд ял шийтгэлийг хөнгөрүүлж оногдуулах, хөнгөн хэрэг дээр ялаас чөлөөлөх хүртэл зохицуулалт оруулж ирсэн. Нөхөн сэргээх эрүүгийн эрх зүйн зарчмын хамгийн гол амин сүнс нь “Хохирол нөхөн төлүүлэх үндэсний тогтолцоо” гэдэг ухагдахуун байдаг. “Хохирол нөхөн төлүүлэх үндэсний тогтолцоо” гэж яагаад нэрлээд байна вэ гэхээр энэ нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогчийн эрх ашгийг хангахаар хязгаарлагддаг зүйл огт биш юм.

Гэмт хэргийн улмаас эрүүл мэндийн хохирол амссан, бие махбод, сэтгэл санааны, зөвхөн тухайн үеийн бие махбодын биш, хожмын үлдэц, урхаг, уршиг гээд тооцвол гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш эрүүгийн процесс яваад дуусаж байхад илэрдэг, үр дагавар нь үргэлжилдэг хор уршиг, хохирлууд байгаад байдаг. Дээрээс нь бид эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэг зүйлийг хаядаг нь гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэрэгт хохирсон хүн хоёр хоорондоо юу болсон бэ гэдэг асуудал юм. Суурин нийгмийн хамгийн том асуудал бол “Гэмт хэрэг гарсны дараа гэмт хэргийн улмаас хохирсон хүн, гэмт хэрэг үйлдсэн хүн хоёр цаашаа эвлэрээд амьдрах орон зай үлдсэн үү?” гэдэг нь маш чухал асуудал. Тиймээс гэм буруугаа хүлээх буюу хоёр хүнийг эвлэрүүлэхийг маш чухалд тооцдог. Энэ бүхнийг шийдвэрлэхийн тулд хохирол нөхөн төлүүлэх үндэсний тогтолцоог бий болгодог. Энгийнээр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн хүн хохирлоо төлж чадахгүй бол хохирлыг нь улсаас гаргах тухай асуудал юм. Гэмт хэргийн улмаас учирсан

хохирлыг барагдуулах асуудал нь маш олон асуудлыг цогцоор шийдэх шаардлага үүсгэдэг тул үүнийг зөвхөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд шийдвэрлэх боломжгүй, тиймээс улс гүрнүүд үндэсний механизм бий болгодог.

Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хохирол нөхөн төлүүлэх тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр хүчин чармайлтаа эрчимжүүлэх шаардлагатай байна. Энэ хүрээнд Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр хохирол төлүүлэх үндэсний тогтолцооны чиглэлээр олон цуврал судалгаа хийгдсэн.³ Гэмт хэргийн хохирлын санг бүрдүүлэх хүрээнд манайд хамгийн сайн хийсэн гэж боддог хэр нь хамгийн дутуу хийсэн хохирлын нэг институт бол эрүүл мэндийн хохирлыг тогтоох, үнэлэх тухай асуудал юм. Бид үнэн хэрэгтээ эрүүл мэндийн хохирлоо ерөөсөө тогтоож чаддаггүй. “Хүний бие махбодод хүнд гэмтэл учрууллаа” л гэж яриад байхаас биш, тухайн хүн мөнгөөр үнэлбэл хэр хүнд гэмтлээс болж хэдэн төгрөгөөр хохирсон юм бэ гэдгийг тогтоодоггүй. Хөдөлмөрийн чадвараа алдаад гэртээ хэд хоног хэвтсэнээр нь тогтооно гэдэг, гэтэл хөдөлмөрийн чадвараа алдах гэдэг ойлголт нь ажил, мэргэжил бүр дээр өөр байна. Тухайн хүн эрүүл байхдаа олдог орлоготой нь харьцуулан хохирлыг үнэлэх байтал гар хугарсан бол “хүндэвтэр”, үндсэн тулгуур эрхтний яс нь хугарсан бол “хүнд” гэдэг ч юм уу хүчээр буюу гүжирмэг байдлаар шийдээд байгаа нь буруу юм. Цаашид бид хохирол төлүүлэх сантай болох байр суурь баримтлах ёстой.

Хуульд шүүгдэгч гэм буруутай нь тогтоогдвол хохирогчийн хохирлын зардлыг түүнээс гаргуулна, хэд хэдэн шүүгдэгч гэм буруутай байвал зардлыг хувааж гаргуулна, хэрэв зардал төлөх боломжгүй, төлбөрийн чадваргүй бол төр хариуцна гээд тодорхой заасан. Гэвч практик дээр хохирогч өмгөөлөгч авсан, эмнэлэгт хэвтсэн, эм тариа авсан зэрэг нотлох баримтаа гаргаж өгсөөр байхад шүүхүүд харилцан адилгүй шийдэж байна. Тэр ч байтугай өмгөөлөгчийн зардлыг гаргах эсэх дээр харилцан адилгүй хандаж байгааг шийдэхийн тулд хуульд тодорхой зааж өгөх, ингэснээр ойлгомжгүй, бүрхэг зохицуулалтаас үүдэн хууль тогтоомжийг өөр өөрөөр хэрэглэх явдлыг таслан зогсоох ач холбогдолтой юм.

3 Нээлттэй Нийгэм Форум, https://forum.mn/erugiin-ehzuin-shinetgeliig-demjih?category_id=13503

ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

- * Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шатанд хүний эрхийн баталгааг хангах чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд наад зах нь дараах асуудлуудыг анхаарч үзэх:
 - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар бүлэгт хохирогчийн хохирлыг шударгаар барагдуулахад шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах;
 - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд туссан шүүхийн зөвшөөрөлтэй холбогдуулан шүүх 24 цаг ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх;
 - Халдашгүй байх эрхийг баталгаажуулсан нэмэлт, өөрчлөлтийг хуульд тусгах.
- * Хуульчид, хууль сахиулагчдын мэдлэг, чадавхыг нэмэгдүүлэх, ажил дүгнэх үзүүлэлтийг хүний эрхийн зарчимд нийцүүлэх;
- * Эрүүгийн процесс дахь хяналт, тэнцвэрийн зарчмыг алдагдуулсан аливаа нэмэлт, өөрчлөлтийг хуульд оруулахаас сэргийлэх;
- * Хохирлын үндэсний тогтолцоог бий болгох.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ОРОЛЦОГЧДЫН НЭРС

1. Б.Алтантуяа - Монголын Эмнести Интернэшнл ТББ-ын Гүйцэтгэх захирал
2. Ч.Гантуяа - МХХ-ны Эрүүгийн эрх зүйн хорооны гишүүн, хуульч
3. Ц.Лхагвацэнд - ХЗДХЯ, Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн
4. О.Мөнхсайхан - МУИС-ийн Хууль зүйн сургууль, хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор
5. Г.Наранбаатар - МХХ-ны зөвлөлийн гишүүн, өмгөөлөгч, хууль зүйн ухааны доктор (Ph.D), дэд профессор
6. Р.Оюунбадам - ХЗҮХ-гийн зөвлөх, хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор
7. Г.Оюунболд - МХХ, Эрүүгийн эрхзүйн хорооны тэргүүн
8. Я.Цэлмэн - ХЭҮК, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, хууль зүйн ухааны доктор (Ph.D)
9. Б.Энхболд - ХЭҮК-ын гишүүн, хууль зүйн ухааны доктор (Ph.D), дэд профессор
10. Г.Эрдэнэбат - Хуульч

Хэлэлцүүлгийг хөтөлж,
тэмдэглэлийг сийрүүлсэн
Б.ХИШИГСАНХАН,
ННФ-ын Эрхзүйн хөтөлбөрийн
менежер



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Хаяг: Монгол Улс,
Улаанбаатар хот-14240,
Сүхбаатар дүүрэг,
Жамьян гүний гудамж-5/1

Утас: 976-76113207
Факс: 976-11-324857
Веб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn